

**ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
АВТОМАШИНЫ ЗОГСООЛЫН ТҮРЭЭСЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР**

Түрээслэгчийг сонгон шалгаруулах зар

1. Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга

Геронтологийн үндэсний төвийн гадна байрлах автомашины зогсоолын нийт талбай 149.96 м² талбайг автомашины төлбөртэй зогсоолын зориулалтаар түрээслэн ажиллуулах түрээслэгчийг сонгон шалгаруулахад Монгол Улсын хуулийн этгээдийг урьж байна.

Байршил: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, 100 айл, Геронтологийн үндэсний төвийн гадна талбай.

2. Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	2026 оны 10 дугаар сарын 05 -ны өдрийн 10 цаг хүртэл.
Материал хүлээн авах хаяг	Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, 100 айл, Геронтологийн үндэсний төвийн 104 тоот өрөө, архив, бичиг хэргийн ажилтан.
Материал нээх хугацаа, хаяг байршил	2026 оны 10 дугаар сарын 05 -ны өдрийн 10 цаг 30 минут. Геронтологийн үндэсний төвийн байр, 302 тоот өрөө. /Материал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор оролцогчдын өмнө нээнэ./
Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ	1 м² талбайн түрээсийн доод үнэ 10,000 (арван мянган) төгрөг. Түрээслүүлэх талбай: 149.96 м².
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Авто зогсоолын үйлчилгээ эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардахгүй. Түрээслэгч нь үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, авто зогсоолын норм, стандарт болон төлбөртэй зогсоол ажиллуулахад хамаарах зөвшөөрөл, гэрээний шаардлагыг хангаж ажиллана.
Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49, 51 дүгээр тогтоолыг үндэслэн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод зохион байгуулна. Оролцогч материалыг бүрэн бүрдүүлж, битүүмжилсэн хэлбэрээр 2 хувь ирүүлнэ. Дугтуйн гадна талд оролцогчийн нэр, хаяг, сонгон шалгаруулалтын нэр, бүрдүүлсэн материалын жагсаалтыг бичнэ. Материал дутуу бол үл маргах журмаар хасна. Шаардлагыг хангасан оролцогчдыг ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээний нийлбэрээр дүгнэж, нэг түрээслэгчийг сонгон шалгаруулна.
Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	1. Хуулийн этгээд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байна. 2. Байгууллагын танилцуулга 3. Сүүлийн 3 жилийн ажлын туршлагын мэдээлэл, өмнө гүйцэтгэсэн ажлын гэрээ, нотлох баримт.

	4. Санхүүгийн чадварыг нотлох сүүлийн 2 жилийн дансны хуулга, үйл ажиллагаа эхлүүлэх эх үүсвэрийн нотлох баримт ирүүлнэ. Үүнд: • Харилцагч банкны дансны үлдэгдэл • Банкны зээлжих эрхийн тодорхойлолт • Хуулийн этгээд сүүлийн 2 жилийн аудитлагдсан тайлан. 5. Шүүхээр тогтоогдсон бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт /E-Mongolia/. 6. Татварын тодорхойлолт /etax.mta.mn/. 7. Хугацаа хэтэрсэн зээлгүйг нотлох зээлийн мэдээллийн сангийн QR кодтой баримт. /E-Mongolia, Сайн скор, Бүрэн скор/ 8. Геронтологийн үндэсний төвийн авто зогсоолын журамтай танилцсан тухай албан бичиг ирүүлэх. /Зогсоолын журам төвийн вэб сайтын Хууль эрхзүй, төвийн захирлын тушаал цэс дотор байршсан байгаа/ 9. Ажиллах хүчний мэдээлэл, үнэмлэхний хуулбар. 10. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт /E-Mongolia/. 11. Талбай түрээслэх үнийн санал: хуулийн этгээд албан бичгээр ирүүлнэ. 12. Үйл ажиллагааны төлөвлөгөө. 13. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийх ажлын санал.
--	---

3. Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

Түрээслэх хөрөнгийг Геронтологийн үндэсний төв дээр очиж үзэж болно.

Сонгон шалгаруулалтын заавар, материал хүлээн авах хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг 11-350801 утсаар авна уу.

**ХАЯГ: СҮХБААТАР ДҮҮРЭГ, 11 ДҮГЭЭР ХОРОО, 100 АЙЛ,
ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ, 104 ТООТ, АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ.**